

БАЙГАЛЬ ОРЧИН БА НИЙГМИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“СЭНЖ САНТ” ХХК, МОНГОЛ УЛС

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|---|---|---|--|---------------------------------------|------------------|--|---------|
| 1 Барилгын ажлын явц, шаардлагатай бол ашиглалтын үе шатанд хэрэгжүүлэх хөтөлбөр | | | | | | | |
| 1.0 | Орон нутгийн Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг болон WSP-н 2012-8-29-нд бэлтгэн гаргасан Байгаль орчин, Нийгэмд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээний нэмэлт баримтуудыг хэрэгжүүлэх. Улсын хууль дүрэм, ЕСХБ-ны гүйцэтгэлийн шаардлагуудад бүрэн нийцүүлэх. | | Европын Сэргэн босголт, Хөгжлийн Банк (ЕСХБ) Дотоод шаардлагууд. | | | | |
| 1.1 | Барилгын, Ашиглалтын болон Засвар үйлчилгээний ажлын явцуудад гүйцэтгэгчдийн байгаль орчин, эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа болон нийгмийн ажлуудыг зохион байгуулах компанийн нэгдсэн бодлогыг бий болгох. Үүнд: 1. Чиглүүлэх ажил. 2. Тохирох ажлуудын төлөвлөгөө, хуулийн шаардлагуудыг гэрээндээ тусгаж өгөх, үүнд: ажилчдад тавигдах шаардлага, удирдлагуудын сургалт, мэдэгдэх аргачлал, хувийн хамгаалалтын хэрэгслийг зөв хэрэглэх арга зэргийг багтаасан аюулгүйн системүүд багтана. 3. Сэнж Сант ХХК-аас гүйцэтгэгчийг хянах | Барилгын болон Ашиглалтын явцад эрүүл мэнд, аюулгүй байдал ба байгаль орчны гүйцэтгэл сайжирна. | Шилдэг туршлага ЕСХБ PR1. ЕСХБ PR2. | Дотоод нөөц. | 2012 оны 8-р сар | Туслах-гүйцэтгэгчийн сургалт болон аваар ослын бүртгэл. Аюулгүйн ажиллагааны бүртгэлийн систем. ЕСХБ-д аюулгүй ажиллагаа болон KPI-н талаар жил болгон тайлагнах. | |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|-----|---|--|---|--|--------------------------|---|---|
| | <p>үүрэг хариуцлагыг тодорхой болгох.</p> <p>4. Гүйцэтгэгчийн ажлын тайлбайг тогтмол хянах. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаар гүйцэтгэлийн тайланг (засан залруулах ажлуудыг багтаасан) тогтмол гаргуулах.</p> <p>5. Гүйцэтгэгчийн байгаль орчин, эрүүл мэнд аюулгүй ажиллагааны менежерүүд болон ажилчдын мэргэжлийн ур чадвар, бэлтгэлийг шалгах.</p> <p>6. Аюулгүй ажиллагааны талаар нээлттэйгээр тайлагнаж байхын тулд ажиллах хүчин болон гүйцэтгэгч нарын санал гомдлыг шийдвэрлэх журмыг ашиглах, хэрэгжүүлэх</p> <p>7. KPI-ийн сар тутмын дотоод тайлан</p> | | | | | | |
| 1.2 | <p>Төслийн ажилчид болон бүх оролцогч талууд гомдол хүлээн авах хуудсыг ашиглах, төслийн явцад бүрэн хамтран оролцох бололцоог хангаж өгөхийн тулд Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө(ОТӨТ)-г төслийн ажлын болон хөрөнгө оруулалтын шатуудад хэрэгжүүлэх.</p> <p>Оролцогч талуудтай харилцах, гомдол барагдуулах, шийдвэрлэх ажлуудыг хариуцсан менежерийг томилох.</p> <p>Олон нийтийн санал гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх гомдол барагдуулах албан ёсны механизмыг бүрэн хэрэгжүүлэх (ОТӨТ-нд тусгасан болно) .</p> | Орон нутгийн иргэдтэй итгэлцлийн харилцааг тогтоох, хадгалах | Менежментийн олон улсын шилдэг туршлага ЕСХБ PR10. | Дотоод нөөц / өгөгдсөн үүрэг хариуцлага. | 2012 оны 8-р сараас хойш | Сэнж Сант ХХК нь гол өөрчлөлтүүдийг төлөвлөхдөө ОТӨТ-ийг ашиглах ба шаардлагатай бол санал гомдол хүлээн авах хуудсыг мөн ашиглана Санал гомдлын талаар мэдээллийг багтаасан жил | Санал гомдол ба түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг дээд удирдлагад сар бүр, ЕСХБ-д улирал бүр тайлагнана. |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|-----|---|---|--|--|---|---|---------------------------------------|
| | | | | | | тутмын тайлан | |
| 1.3 | Байгаль орчин ба нийгмийн ажлуудын төлөвлөгөөний гүйцэтгэл, үзүүлэлт болон санал гомдлыг хэрхэн шийдсэн талаар тайлан гаргаж өгө | Байгаль орчинтой холбоотой ажлуудын гүйцэтгэлийн хяналт. | ЕСХБ PR1. | Дотоод нөөц. | ЕСХБ-д жил бүр гомдол саналыг хэрхэн шийдвэрлэсэн тухай тайлагнах | Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон нийгмийн ажлуудын тайлан танилцуулга | Төслийн бүх шатуудад ЕСХБ-д тайлагнах |
| 1.4 | ОТӨТ, Байгаль орчин ба Нийгмийн Менежмент, Хяналт Шалгалтын Төлөвлөгөө (БОНМХШТ), Байгаль орчин ба Нийгмийн Ажлын Төлөвлөгөө (БОНАТ) болон ЕСХБ-ны байгаль орчин, нийгмийн бодлогын дагуу төслийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх хариуцлагатай менежерийг томилох. Тус менежер нь ЕСХБ-ийн шаардлагуудыг мэддэг, байгаль орчин, эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны талаар зохих мэдлэгтэй байх ёстой. Хэрвээ эдгээр шаардлагуудад тохирох хэн нэгэн олохгүй байвал тусгай томилгоог хийх ёстой. | Барилга болон ашиглалтын явцуудад байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанууд сайжирна | Шилдэг туршлага ЕСХБ PR1. ЕСХБ PR2. | Дотоод нөөц. | Барилгын ажил эхлэхээс өмнө | | |
| 1.5 | ЕСХБ-ын А ангилалын шаардлагуудын дагуу байгаль орчин болон нийгмийн шинэ, нэмэлт мэдээллүүдийг танилцуулах, олон нийтийн хурал зөвлөгөөнийг зохион байгуулах | Үнэн зөв мэдээллийн нээлттэй байдал үүснэ. Орон нутгийн иргэдийн төслийн талаархи мэдлэг | ЕСХБ PR10. | Дотоод нөөц / Гадны зөвлөхийн туслалцаа. | ОТӨТ-д тусгасан хуваарийн дагуу төлөвлөгөөт зөвлөлдөх уулзалтуудыг зохион | ОТӨТ-ийн дагуу зөвлөгөө ба мэдээлэл өгөх уулзалтуудыг зохион байгуулах | |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|-----|---|---|--|--|--|--|--|
| | | нэмэгдэнэ. Оролцогч талуудаас мэдээллийг хүлээн авах | | | байгуулах. Байгаль Орчин Нийгмийн Нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-г дэлгэснээс хойш 60 хоногт багтаан олон нийтийн зөвлөгөөн, нээлттэй уулзалтуудыг зохион байгуулах | | |
| 1.6 | Байгаль орчин, нийгмийн нэмэлт мэдээлэл болон БОНМХШТ-г бүрэн хэрэгжүүлэх. Орон нутгийн хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллүүдтэй холбоотой менежментийг төлөвлөгөөг боловсруулах | Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийн бууралт | ЕСХБ PR1 ЕСХБ PR4 | Дотоод нөөц / Гадны зөвлөхийн туслалцаа. | Барилгын ажил эхлэхээс өмнө | Менежментийн төлөвлөгөөг ашиглалтын явцад хэрэгжүүлэх, бүртгэлийг хийх | Төлөвлөгөө нь ЕСХБ-р хянагдсан байх ёстой бөгөөд боломжит нөлөөллийн хүрээ, барилгын болон ашиглалтын шатуудын менежментийн хариуцлагыг илрүүлэн тусгасан байх ёстой. Түүнчлэн шилжилт |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|-----|---|--|--|---------------------------------------|--|--|--|
| | | | | | | | хөдөлгөөнтэй холбоотойгоор жендерийн мэдрэмжийн шигжилгээ хийх хэрэгтэй. |
| 1.7 | Талбайн баруун хилийн дагуу байгалийн далан барих, харагдах үзэмжийг сайжруулах, байгалийг зохих төрхөнд нь оруулах | Орон нутагт нөлөөлөх чимээ шуугиан болон харагдах нөлөөллүүдийн бууралт. | ЕСХБ PR4. | Барилгын ажил гүйцэтгэгч | Барилгын ажлын газар шорооны ажил дуусахаас өмнө | Зураг төслийн дагуу далангийн ажил гүйцэтгэх | |
| 1.8 | <p>Монголын ШУ Академийн дэргэдэх археологийн хүрээлэнтэй зөвлөлдөж төслийн хэрэгжих газарт боломжит археологийн өвүүдийн дэлгэрэнгүй үнэлгээг хийлгэх.</p> <p>Археологийн менежментийн төлөвлөгөө нь энэхүү дэлгэрэнгүй үнэлгээн дээр үндэслэн барилгын болон үйл ажиллагааны үед хөндөгдөж болшгүй өвүүдийг хадгалан үлдээх арга хэмжээнүүдийг агуулна..</p> <p>Компани барилгын ажлын явцад системийг хадгалах бүх боломжийг хайн хэрэгжүүлэх болно.</p> | Археологийн өвийн хамгаалалт | Монгол улсын хууль дүрэм. ЕСХБ PR8. | Дотоод нөөц. | Барилгын ажил эхлэхээс өмнө | Хэлэлцүүлгийн үр дүн Археологийн үнэлгээний ажлын дэлгэрэнгүй тайлангийн хуулбар (хэрвээ шаардвал) болон археологийн менежментийн төлөвлөгөөг ЕСХБ-д танилцуулах. | Орон нутгийн захиргаатай зөвшилцөн малталт болон бусад ажлуудыг төлөвлөнө. Бүртгэл хийгдэнэ. |
| 1.9 | Гэрэлтүүлгийн зураг төслийг боловсруулах ба үүнд эргэн тойрны нөлөөлөлд автаж болзошгүй газруудыг авч үзнэ | Өргөн сум ба орон нутгийн экологид | ЕСХБ PR3. ЕСХБ PR6. | Дотоод нөөц / Гадны зөвлөхийн | Зураг төслийн ажил дуусахад | Зураг төслийн үзүүлэлтүүд | Техникийн бус тодорхойлолтын (ТБТ) |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|------|--|--|--|---|--|---|---|
| | | үзүүлэх гэрэлтүүлгийн нөлөөллийн бууралт | | туслалцаа. | | | Гэрэлтүүлгийн бүлэг болон нэмэлт мэдээллийн тайлангийн гэрэлтүүлгийн бүлэгт тусгасны дагуу арга хэмжээг авна |
| 1.10 | Уурхайн нөхөн сэргээлтийн ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулах | Орон нутгийн биологийн тархалтыг зохицуулах, хянах ба бэхжүүлэх | ЕСХБ PR6. | Дотоод нөөц. | Ашиглалтанд оруулахаас доод тал нь 1 жилийн өмнө | Уурхайн нөхөн сэргээлтийн болон менежментийн төлөвлөгөөний баримтууд. Хийгдэж буй нөхөн сэргээлтийн талаарх мэдээллээр хангах | Монгол ба Англи хэлээр хэвлэж Сэнж, Сүмбэр баг болон Сайшанд дахь аймгийн захиргаанд байрлуулна. |
| 1.11 | Ховор болон ховордож буй төрөл зүйлүүд ажлын талбайд, цементийн үйлдвэр ба карьерийн талбайд, цахилгааны шугам болон ус дамжуулах хоолойн чиглэлд байгаа эсэхийг тодруулах цаашдын хяналт шинжилгээг гүйцэтгэх ба нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулах. Үүний тулд талбайд хэд хэдэн удаа айлчилж, судалгаа хийх шаардлагатай. | Экологийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан эсэхийг баталгаажуулах. | ЕСХБ PR6. | Дотоод нөөц ба чадварлаг экологч / шувуу судлаач болон олон улсын шинжээчээр хянуулах | 2013 Оны 2р сар гэхэд судалгааны цар хүрээг ЕСХБ-н хамт ярилцан тохирсон байна. Барилгын ажил эхлэхээс | Судалгааны тайлан болон нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжүүлэлтийн баталгаанууд шаардлагатай ЕСХБ-д хүлээлгэн өгнө | Биологийн тархалтын талаархи нэмэлт судалгааг хийн ЕСХБ-д тусгасан экологийн ба шувуу судлалын мэргэжилтнүүдэд танилцуулна. Барилгын ажил |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|------|--|-------------------------------------|--|--|--|---|---|
| | <p>Үржлийн болон нүүдлийн гол улирлуудад Шувуун Хөөвөрийн булгийн эргэн тойронд ховор болон онц анхаармаар төрөл зүйл илэрж байгаа эсэхийг хянах судалгаануудыг явуулах. Биотархалтын төрлүүд илэрвэл тэдгээрийн үнэлгээг хийж, тэдгээрийг нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Тоо хэмжээг нь хадгалахын тулд нүүлгэн шилжүүлэх гэх мэт.</p> | | | | <p>өмнө судалгаа шинжилгээг гүйцэтгэнэ.</p> | | <p>эхэлснээс хойш таван жил тутамд нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээний хяналт шинжилгээг гүйцэтгэнэ.</p> |
| 1.12 | <p>Барилгын ажлаас гарч буй бохир усыг цэвэршүүлэх, цэвэр усны хэрэглээг багасгахын тулд бохир ус цэвэршүүлэх системийг ашиглалтанд эрт оруулах</p> <p>Бохир усны цэвэршүүлэлтийг Хамгийн Сайн Боломжит техник ба БОННУ-д тодорхойлогдсон зааврын дагуу хийх.</p> <p>Үйлдвэр зогссон үед хөргөлтийн усны түвшинг нэмэгдүүлэх шаардлагагүй тул ус сэлбэх болон дахин боловсруулахтай холбоотой тоног төхөөрөмжүүдэд төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний системийг бүрэн хэрэгжүүлнэ</p> | Усны тогтвортой менежмент | ЕСХБ PR6. | Дотоод нөөц ба бохир ус цэвэршүүлэх системийн зардал | <p>Барилгын ажил эхлэхээс өмнө бохир ус цэвэршүүлэх байгууламжтай болох</p> <p>PPM системийг үйлдвэр ашиглалтанд орохоос өмнө буюу зураг төслийн шатанд баталгаажуулах</p> | <p>Үйлдвэр орон нутгийн зөвшөөрөл шаардлагын дагуу ажиллах боломжтойгоор бэлэн байх</p> <p>Ашиглалтанд оруулахаас өмнө PPM бэлэн байна.</p> | |
| 1.13 | Гүний усны хэмжээ нь төсөлд шаардлагатай усны хэрэгцээг хангаж чадах эсэхийг шалгахад | Байгаль орчинд нөлөөлөх | ЕСХБ PR6. | Дотоод нөөц ба гүний усны | Барилгын ажил эхлэхээс | Үнэлгээний тайлан. | ЕСХБ-с томилсон гуравдагч талын |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|------|--|---|--|---------------------------------------|---|------------------------------------|--|
| | <p>Гидрогеологийн нарийвчилсан үнэлгээ ба гүний усны загварчлалыг ашиглана. Нэмэлт мэдээллийн тайлан ба техникийн бус мэдээлэлд тусгасны дагуу Нэмэлт судалгаа шинжилгээг гүйцэтгэх бөгөөд үүнд хойд, өмнөд уст давхаргуудын нарийвчилсан үнэлгээ болон, холбогдох нөлөөллүүдийг багтаана.</p> <p>Зураг төслийн эцсийн хувилбарт усны гаралт болон, нөхөн сэргээгдэх хэмжээ нь одоогийн байгаа гадаргын усны хэмжээнд нөлөөлөхгүйгээр үйлдвэрийн үйл ажиллагааг усаар хэвийн хангах төлөвлөгөөг багтаасан байна</p> <p>Хамгийн эцсийн зураг төсөлд үйлдвэрийн ашиглалтын явцад шаардлагатай хэмжээний усыг хангах эх үүсвэрүүдийг тусгах, усны тогтмол гарцын хэмжээ болон, сэлбэгдэх хүчин чадал болон хэрэглэх усны хэмжээ нь одоогийн гадаргын усанд нөлөөлөх нөлөөгүй байна гэдэг мэдээллүүдийг бүрэн багтаах.</p> | нөлөөлөл буурна | ЕСХБ PR4. | зөвлөгч гадаад мэргэжилтний туслалцаа | өмнө зураг төслийн эцсийн шатанд | | гүний усны мэргэжилтнүүдээр нэмэлт ажлууд болон үнэлгээний тайланг хянуулна. |
| 1.14 | <p>Үйлдвэрлэлээс: ажлын баазууд, офиссууд, захиргааны бүсүүдээс гарж буй бохир усыг Хамгийн Сайн боломжит техникийн шаардлагуудын дагуу бохир ус цэвэршүүлэх байгууламжийн зураг төслийг гаргах, хэрэгжүүлэх. Усыг зохих ёсны дагуу цэвэршүүлэн ундны бус зориулалтаар (жишээ нь тоос дарах зориулалтаар) хэрэглэж болохыг</p> | Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл буурна | ЕХ IPPC/ Агаарын чанарт нөлөөлөх үйлдвэрлэлийн хог хаягдлын удирдамж | Дотоод нөөц. | Барилгын ажил эхлэхээс өмнө зураг төслийн эцсийн шатанд | Хяналт шинжилгээний үр дүн | |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|------|--|--|--|---|---|--|---|
| | баталгаажуулах. | | | | | | |
| 1.15 | <p>Нүүрсэн галлагаатай бойлерын зураг төсөл ба хэрэгжүүлэлт нь төслийн дараах үзүүлэлт, шаардлагыг хангасан байна:</p> <ul style="list-style-type: none"> • Тархалтын шинэчилсэн загварчлалыг хийх ба үүнд ADMS эсвэл AERMOD программ хангамжийг ашиглаж хаягдлын нөлөөллийг үнэлнэ (зураг төслийн параметрийг бэлэн болоход). • Ширхэглэл бүхий хаягдлыг 20мг / Nm³-т хүргэх уутан шүүлтүүрэн системийн харьцуулалт хийх ба хаягдал илрүүлэх систем нь тохирч байгаа эсэхийг баталгаажуулах. • Нүүрсэн галлагаатай бойлерыг жил тутмын хяналт шинжилгээний ажлыг төлөвлөх. Хяналт шинжилгээний техникээр жил тутмын хяналт шинжилгээний ажлыг хийж 20мг/Nm³ хязгаарыг ISO ба EN стандартуудын дагуу хянана (Нэмэлт мэдээллийн тайлангийн хавсралт 3.1) • Хүхэр багатай нүүрс (1.2%-иас бага хүхрийн агуулгатай) хэрэглэх ба нийлүүлэгчээс нүүрсний гэрчилгээг авах. • Нүүрстөрөгчийн түвшинг хянах үүднээс шаталтын автомат системийг хэрэглэх, нүүрсний шаталт, нүүрстөрөгчийн исэл | <p>Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл буурна</p> <p>Нөөцийг зөв зохистой хэрэглэх, агаарын чанарыг хамгаалах</p> | <p>EX IPPC Хамгийн Сайн боломжит техник: шаталтын тухай ЕСХБ PR3 ба PR6.</p> | <p>Шинэчилсэн загварчлалын зардал.</p> <p>Бохирдуулалтыг хянах системд шаардлагатай зардал.</p> | <p>Барилгын ажил эхлэхээс өмнө зураг төслийн эцсийн шатанд Нарийвчилсан мэдээллийг ЕСХБ-т хүлээлгэн өгч батлуулна</p> | <p>Тогтсон зураг төсөл ба Тогтсон хаягдлын хязгаар</p> | <p>Ажил эхлэхээс өмнө зураг төслийг ЕСХБ-д танилцуулан батлуулна.</p> <p>1.2%-ас бага хувийн хүхрийн агуулгатайг харуулсан нүүрсний гэрчилгээг ЕСХБ-д хүлээлгэн өгнө.</p> |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|------|---|---|--|--|---|---|--|
| | <p>зэргийг бууруулна.</p> <ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх. • Ашиглалтанд ороход үнэлгээний ажлыг гүйцэтгэн үнсийг нэмэлт түүхий эд болгож цементийн хольцонд хэрэглэх боломжийг судлах | | | | | | |
| 1.16 | <p>Цементийн үйлдвэрийн болон нүүрсэн галлагаатой бойлерын нарийвчилсан зураг төсөл нь БОНАТ-ий Бүлэг 2-т заасан шаардлагуудыг хангаж буй эсэхийг шалгах. Нүүрс боловсруулах болон нунтаглах, үлээх хэсгүүдийн орчинд үүсч болох тэсрэлттэй холбоотой эрсдлийн бүрэн үнэлгээ хийсэн эсэхийг шалгах.</p> | Байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах | EX IPPC BREF цементийн үйлдвэрлэл | Үйлдвэрийг ашиглалтанд оруулахад хэрэгтэй нөөц | Нарийвчилсан зураг төсөл бэлэн болоход. Бүх зураг төслийн нарийвчилсан мэдээллийг ЕСХБ-д танилцуулах ба энэ нь БНҮТ-тэй хэрхэн нийцэж байгааг тодруулах | Үйлдвэрийн зураг төслийг Хамгийн сайн боломжит техник стандартын дагуу энэхүү бүлгийн 2-т тусгасан шаардлагуудад нийцүүлэн гаргах | Ажил эхлэхээс өмнө ЕСХБ-д зураг төслийг танилцуулж батлуулах |
| 1.17 | <p>Өргөн тосгоны шинэ худгийн тухай.</p> <p>Шинэ усны нөөцийн менежментийг хариуцсан улсын албан хаагчидтай хамтран ажиллахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Худгийн нөөц нь орон нутгийн хүн амын өсөлтийн үед ч шаардлагатай усыг хангаж чадахуйц усны тогтвортой | Сумыг шаардлагатай цэвэр усаар хангах | ЕСХБ PR6. | Худгийг ашиглахад шаардлагатай нөөцүүд | Өмнөд уст давхаргаас ус авах эсвэл Сэнжит Худгийн уснаас ус авах бусад өөрчлөлтүүд | Шинэ усан хангамжтай байх | |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|------|---|---|--|--|--|--|---------|
| | <p>ундаргатай байна</p> <ul style="list-style-type: none"> - Тосгоны хуучин худгийн усны чанарын шинжилгээ болон, гидрокарбонатын бохирдлын үнэлгээг хийлгэх - Ундны усаар хангахын тулд шаардлагат бол ус цэвэршүүлэх системийг хэрэглэх. - Худгийн ашиглалтын менежментийг орон нутгийн албан тушаалтнууд хариуцах | | | | йг хийхээс өмнө | | |
| 1.18 | Аваар ослыг бүртгэх, тэмдэглэх ба үүнд гүйцэтгэгчийн аюулгүй ажиллагаа хамаарна | Эрүүл мэнд ба аюулгүй байдлын үр ашигтай менежмент. | ЕСХБ PR2. | Дотоод нөөц | Барилгын ажил эхлэхээс өмнө | Аваар осол бүртгэх, тайлагнах, албан хаагчдийг дадлагажуулах, сургалтанд хамруулах зэрэг шаардлагуудыг үүнд тусгах | |
| 1.19 | Ажлын бүх талбарт үнэлгээний ажлыг гүйцэтгэх бөгөөд үүгээр аюулгүй байдал, болон ажлын талбайд нэвтэрч байгаа бүх хүмүүст эрүүл мэнд ба аюулгүйн эрсдлийн талаарх мэдээлэл, журмаас танилцуулах | Эрүүл мэнд ба аюулгүй байдлын үр ашигтай менежмент | ЕСХБ PR 2 EX зөвлөмж 92/58/ЕЕС Аюулгүйн тэмдэг | Дотоод нөөц / Гадны зөвлөхийн туслалцаа. | Үйлдвэрийн ажил эхэлснээс хойш нэг сарын дотор | Эрүүл мэнд, аюулгүйн байдлын үнэлгээний баримт бичиг | |
| 1.20 | Хувийн хамгаалах хэрэгсэл, түүний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх (PPE). Энэ бодлогыг хэрэгжүүлэн тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авахаас өмнө ажилчдын саналыг авсан | Эрүүл мэнд ба аюулгүй байдлын үр ашигтай | ЕСХБ PR 2 EX зөвлөмж 89/656/ЕЕС – PPE. | Дотоод нөөц / Гадны зөвлөхийн туслалцаа | Үйлдвэрийн ажил эхлэхээс өмнө | PPE төлөвлөгөө ба бодлого | |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|------|---|--|---|--|---|--|---------|
| | эсэхийг баталгаажуулах. | менежмент | | | | | |
| 1.21 | Ажлын байранд авсан аливаа шинэ тоног төхөөрөмж бүр нь эрүүл мэнд ба аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах | Эрүүл мэнд ба аюулгүй байдлын үр ашигтай менежмент | ЕСХБ PR 2 EX зөвлөмж 89/655/EEC - Ажлын тоног төхөөрөмж. | Дотоод нөөц. | Үйлдвэрийн зураг төсөл дуусахын өмнө | | |
| 1.22 | Талбайд ирж буй хүмүүс/ гүйцэтгэгч нарт эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжийг танилцуулсан эсэхийг баталгаажуулна | Эрүүл мэнд ба аюулгүй байдлын үр ашигтай менежмент. | ЕСХБ PR2. | Дотоод нөөц. | Барилгын ажил эхэлснээс хойш болон ашиглалтын явцад | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бүртгэл | |
| 1.23 | Үйлдвэрт ажилчин элсүүлэх бодлого боловсруулахдаа дараах асуудлуудыг тусгана: ялгаварлан гадуурхах, тэгш боломж, залуу хүмүүсийн ажил эрхлэлт, цалин (цалингийн хэмжээ, үндсэн ба илүү цагийн), ажлын цаг, үр өгөөж, ажилчдын гомдол саналыг боловсруулах механизм, үйлдвэрчний эвлэл, эрүүл мэнд ба аюулгүй байдал гэх мэт. Түүнчлэн авилгал, хээл хахууль, төлбөр, бэлэг дурсгал, дарамт шахалт, зөрчил, хүний эрх болон бусад асуудлуудыг тусгана. | Ажлын шаардлагын үр дүнтэй менежмент. Ажил олголтын шударга нөхцөл | Шилдэг туршлага ЕСХБ PR2 Монголын хөдөлмөрийн тухай хууль болон бизнес эрхлэлттэй холбоотой хуулиуд | Дотоод нөөц. | Барилгын ажил эхлэхээс өмнө | Шинэ бодлого боловсруулах СБХЕ-г танилцуулахаар өгөх | |
| 1.24 | Үйлдвэрийн цех хэсгүүдийн чимээ шуугианы түвшинг бууруулахын тулд чимээний зураглал гаргах. | Ажлын байрны дуу чимээний түвшин багасах | Ажилчны хамгаалалт / EX IPPC стандарт – Ажлын байран дахь дуу чимээ. ЕСХБ PR2 ба | Дотоод нөөц эсвэл Гадны зөвлөхийн туслалцаа. | Үйлдвэр ашиглалтанд орсноос хойш –2014 онд гэж тооцож байгаа. | Дуу чимээний хязгаарыг давсан тоон үзүүлэлт | |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|------|---|---|--|---|--|--|---|
| | | | PR4. | | | | |
| 1.25 | Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх замын хөдөлгөөний дуу шуугиан 1 дБ-с давах эсэх, орон сууцны ойр орчимд дахь талбайн дуу шуугиан 63 дБ хүртэл өсөж байгаа эсэхийг илрүүлэхийн тулд барилгын 50 м-ийн эргэн тойронд байх одоо байгаа болон, шинээр тавигдах замуудын чимээ шуугианы түвшинг үнэлэх, хэмжих. | Дуу чимээний түвшинг бууруулах | Шилдэг туршлага ЕСХБ PR2. ЕСХБ PR4. | Гадны зөвлөхийн туслалцаа | Барилгын ажил эхэлснээс хойш нэг сарын дотор | Дуу чимээний хяналт шинжилгээний тайлан | |
| 1.26 | Газар эзэмшлийн тогтолцоог бүрэн хэрэгжүүлэх | Орон нутгийн иргэдтэй итгэлцлийн харилцааг бий болгох, хадгалах Газрыг одоо ашиглаж байгаа хүмүүст нөлөөлөх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх. | ЕСХБ PR5. | Дотоод нөөц болон Гадны зөвлөхийн туслалцаа | Барилгын ажил эхлэхээс өмнө | Тогтолцоог хэрэглэж байгаа болно | Төслийн явцын эхэнд аливаа материаллаг ба эдийн засгийн асуудлуудыг энэхүү тогтолцоонд тусгасан байна. Малчдад шаардлагатай усны нөөц болон бэлчээрийг үүнд тусгана |
| 1.27 | Үйлдвэрийн ажиллах хүчнийг бэлдэх төлөвлөгөөг боловсруулахдаа нутгийн иргэдийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг оруулна. Зарим мэргэжлийн сургалтыг Сайншандын мэргэжлийн сургалт үйлвэрлэлийн төв зэрэг орон нутгийн байгууллагуудтай хамтран явуулна. | Орон нутгийн иргэдтэй итгэлцлийн харилцааг бий болгох, хадгалах Төслөөс орон нутгийн эдийн | ЕСХБ PR2. | Дотоод нөөц. | Барилгын ажил эхлэхээс өмнө | Төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа болно. Ур чадварыг нь дээшлүүлсэн хүмүүсийн тоо | Ирээдүйд харьцуулалт хийхийн тулд орон нутгийн иргэдийн өнөөгийн боловсролын түвшингийн |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|------|---|---|--|---|--|---|---|
| | | засаг ба нийгмийн хөгжилд үзүүлэх өгөөжийг нэмэгдүүлэх | | | | | суурь судалгааг хийж баримтжуулах. |
| 1.28 | Нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт (Нэмэлт мэдээллийн тайлангийн Бүлэг 6-д заасны дагуу)-ийг хойд уст давхаргын ус дамжуулах хоолойн барилгын ажлын явцад гүйцэтгэнэ. Энэ нь орон нутгийн гадаргын усны түр зуурын нөлөөллийг бууруулахад шаардлагатай. | Орон нутгийн иргэдтэй итгэлцлийн харилцааг бий болгох, хадгалах | ЕСХБ PR5 ба PR6. | Барилгын сайн менежмент: барилгын гүйцэтгэгчийн нөөцүүд | Барилгын явцад төлөвлөгөөг хэрэгжүүлнэ | Нөлөөллийг бууруулах арга хэмжээг баримтжуулан хэрэгжүүлэх. Төлөвлөгөөг ЕСХБ-д барилгын ажил эхлэхээс өмнө танилцуулах | Ус дамжуулах хоолойн сувгийг буцаан дүүргэх, ус нэвчих бусад өөр зам гаргахаас зайлсхийх. |
| 1.29 | Өргөн сумын оршин суугчидтай уулзан толгодын оройд байрлах овооны талаар ярилцана. Овоонд очих замыг тодруулан төмөр замын өргөтгөл, туузан дамжуулагч зэргийн байршлуудыг эцсийн зураг төсөлд нарийвчлан тусгах нь олон нийтийн зам гармыг чөлөөтэй зохицуулахад тустай. | Орон нутгийн иргэдтэй итгэлцлийн харилцааг бий болгох, хадгалах Газрыг одоо ашиглаж байгаа хүмүүст нөлөөлөх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх. | ЕСХБ PR5, PR8 ба PR10. | Тохиромжтой зам гарам байгаа эсэхийг баталгаажуулах | Зураг төсөл дуусахаас өмнө | | Овоо руу өөр зам гаргахаас сэргийлэх, зайлсхийх |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|------|---|---|---|--|--|--|--|
| 1.30 | Усан хангамжийн стратегийг боловсруулсны дараа орон нутгийн малчидтай албан ёсны уулзалтууд хийнэ. ОТОТ болон газар эзэмшилтийн тогтолцоонд тусгасан уулзалтуудын үүрэг даалгаврыг малчдад ойлгуулж, усны эх үүсвэр болон усанд нөлөөлж болзошгүй нөлөөллүүдийг танилцуулах, нүүдэлчин малчдыг шаардлагатай бол шинэ усны эх үүсвэр рүү нүүлгэх зэрэг арга хэмжээг авна. | Орон нутгийн иргэдтэй итгэлцлийн харилцааг бий болгох, хадгалах Газрыг одоо ашиглаж байгаа хүмүүст нөлөөлөх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх. | ЕСХБ PR5 ба PR10. | Усны эх үүсвэр өөрчлөгдсөн тохиолдолд малчид бэлчээрийн өөр газарлуу нүүх боломжийг дэмжих | 1.14 нөхцөлд дурдагдсан техникийн судалгаа болон Усан хангамжийн стратегийг боловсруулж дуусахаас өмнө | | Бодлого судлалын хүрээлэн, Газрын менежментийн нийгэмлэг зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтрах, түншлэх ба малчдад нөлөөлөх нөлөөллийг ойлгох, бууруулах арга хэмжээг авах |
| 1.31 | Төслийн барилгын ажлын болон ашиглалтын үе шатанд ажилчдын түр сууринтай холбоотой үр ашигтай менежментийг баталгаажуулах үүднээс нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх: - ЕСХБ/IFC-тэй нийцүүлэх (2009) Ажилчдын байрны удирдамж: Процесс ба стандарт'. Үүнд хангалттай зай, халаалт, гэрэлтүүлэг, агааржуулалт, эрүүл ахуй (ус ба бохир усны цэвэршүүлэлт, хоол хийх, угаах ба цэвэрлэх газар, эрэгтэй, эмэгтэй ажилчдад зориулсан амьдрах өрөөнүүд зэрэг асуудлуудыг зохицуулсан байна. - Орон нутгийн иргэдтэй харилцах зохицуулалтыг хийх үүднээс барилгын ажилчдад зориулсан дүрмийг боловсруулах, | Ажлын шаардлагын үр дүнтэй менежмент. Ажил олголтын шударга нөхцөл Орон нутгийн иргэдтэй итгэлцлийн харилцааг бий болгох, хадгалах | ЕСХБ PR2 ба ЕСХБ/IFC (2009) Ажилчдын байр: Үйл ажиллагаа ба стандартууд | Дотоод нөөц | Барилгын ажил эхлэхээс өмнө (түр суурингийн барилгын ажил) болон ашиглалтын ажил эхлэхээс өмнө (үйлдвэрийн ажилчдын байр). | Зохих зохицуулалтыг хийх ба ЕСХБ-д төлөвлөгөөг танилцуулах | |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|--|---|--|--|---|---|---|---------|
| | хэрэгжүүлэх. | | | | | | |
| 2 Ашиглалтанд оруулах, ашиглалтын үе шаттай холбоотой хөтөлбөрүүд | | | | | | | |
| 2.1 | <p>Байгаль орчин болон аюулгүй байдлын менежментийн системийг ISO 14001 ба OHSAS 18001-н дагуу боловсруулна.</p> <p>Байгаль орчны менежментийн хэрэгжилтийн дагуу байгаль орчны менежментийн сургалтыг компанийн хэмжээнд зохион байгуулна.</p> <p>KPI-г төсөлд нэвтрүүлж Дэлхийн бизнесийн зөвлөлийн “Цемент тогтвортой үндэс” зөвлөмжийн дагуу нийгмийн хариуцлагын тайлан гаргана.</p> | Үр өгөөжийг дээшлүүлэх үүднээс хяналт шинжилгээг хийх | Менежментийн олон улсын шилдэг туршлага ECXB PR1. | Дотоод нөөц эсвэл Гадны зөвлөхийн туслалцаа | Ашиглалтын үе шат эхлэхээс өмнө | EHS системийг олон улсын стандартын дагуу боловсруулсан (ISO 14001, OHSAS 18001). | |
| 2.2 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тэр тусмаа аюултай хог хаягдлыг хадгалж буй газарт (тос, тосолгооны материал, шатахуун ба химийн төрлийн хог хаягдал, цахилгааны эх үүсвэрээс гарах үнс гэх мэт). Төлөвлөгөөгөөр хог хаягдлыг талбайд, эсвэл талбайн гадна дахин ашиглах боломжийг нэмэгдүүлнэ. | Хог хаягдлыг зөв зохистой тэмдэгжүүлсэн саванд хадгалж байгаа эсэхийг баталгаажуулах | Шилдэг туршлага ECXB PR3. | Дотоод нөөц. | 2014 оны сүүлээр | Аудитыг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тогтмол хэрэгжүүлэх | |
| 2.3 | Уурхайн менежмент, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг WBC SCI журам ба Лафаржийн шаардлагын дагуу боловсруулах Менежментийн товч мэдээлэл ба нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг веб хуудсанд нийтлэх. | Уурхайн нөхөн сэргээлтийн тохирох менежментийг баталгаажуулах | ECXB, Шилдэг туршлага, Лафарж стандартууд. | Өөрийн /Гадаад | Үйлдвэр ашиглалтанд орсноос хойш 2 жилийн дотор | Тайлан | |
| 2.4 | Биологийн тархалт ба эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн талаархи Лафаржийн стандартууд ба дүрэм журмыг хэрэгжүүлэх. | Шилдэг туршлага нийцүүлэх | Лафарж стандартууд | Дотоод | Үйлдвэрийн ажил эхлэхэд | | |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|-----|--|--|---|---|---|--|---|
| 2.5 | Үйл ажиллагааг эхлэхээс өмнө Аваар осол болон онц яаралтай үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, журам боловсруулах. | Аваар ослын үеийн бэлэн байдал | ЕСХБ PR1, PR3 & PR4. EX IPPC/ Үйлдвэрлэлийн хаягдлын стандартууд. | Дотоод нөөц. | Барилгын ажлын шатанд хэрэгжүүлэх төлөвлөгөө. Ашиглалтын шатанд дахин хянах, шинэчлэх. | Аваар ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө | Барилгын ажил эхлэхээс өмнө яаралтай үед буюу аваар ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах. Ашиглалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө төлөвлөгөөг зохих газраар баталгаажуулах. |
| 2.6 | Хамгийн Сайн Боломжит техникийн шаардлагуудыг төслийн 2-р шатны байгууламжуудын нарийвчилсан зураг төсөлд тусгах. Үйлдвэрийн үйл ажиллагаа Хамгийн Сайн Боломжит техникийн баримт бичигтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах Цементийн үйлдвэр болон нүүрсэн галлагаатай бойлерын хаягдлын түвшин, ажиллагааны гүйцэтгэлийг Хамгийн Сайн Боломжит техникийн хяналтын дагуу бүрэн хянах. Хамгийн Сайн Боломжит техникийн шаардлагын түвшинд хүргэхийн тулд холбогдох арга хэмжээнүүдийг авах. | Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл буурна, Үйлдвэрийн бүтээмж дээшилнэ | EX IPPC/ I Үйлдвэрийн хог хаягдал бууруулах зөвлөмж ЕСХБ PR3. | Дотоод нөөц эсвэл Гадны зөвлөхийн туслалцаа | Зураг төслийн ажил дуусахаас өмнө | Хамгийн Сайн Боломжит техникийн дагуу үнэлнэ | Тендерийн төгсгөлийн шатны өмнө зураг төслийн гүйцэтгэгчтэй Хамгийн Сайн Боломжит техникийн шаардлагыг хэлэлцэнэ. |
| 2.7 | Шинэ байгууламж дахь нөөцлүүрийг суурилуулахдаа | Байгаль орчинд | EU IPPC/ | Дотоод нөөц. | Зураг төсөл | Зураг төслийн | |

Сэнж Сант Цементийн үйлдвэр: Байгаль орчин ба нийгмийн хөтөлбөрийн төлөвлөгөө

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|-------|--|--|--|---|--|------------------------------------|------------------------------|
| | тохиромжтой булалтыг хийх. Ингэхдээ хамгаалалтын булалтын хэмжээ нь нөөцлүүрийн нийт эзлэхүүний 25 хувийг эзлэх,эсвэл том нөөцлүүрийн хувьд хамгийн багадаа 110 хувийг эзлэх ёстойг анхаарах хэрэгтэй. | нөлөөлөх нөлөөлөл буурна | Үйлдвэрийн хог хаягдал бууруулах зөвлөмж | | дуусахаас өмнө | техникийн шаардлага | |
| 2.8 | Усны нөөцлүүрүүд нь өндөр түвшний дохиололтой байгаа эсэхийг баталгаажуулах ба туршилтын хуваарийг боловсруулах | Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл буурна | EX IPPC/ Үйлдвэрийн хог хаягдал бууруулах зөвлөмж | Дотоод нөөц. | Зураг төслийн ажил дуусахад | Зураг төслийн техникийн шаардлага | |
| 2.9 | Усны нөөцлүүр ба холбогдох ус дамжуулах хоолойн хяналтын хуваарийг боловсруулах | Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл буурна | EX IPPC/ Үйлдвэрийн хог хаягдал бууруулах зөвлөмж | Дотоод нөөц. | Зураг төслийн ажил дуусахад | Зураг төслийн техникийн шаардлага | |
| 2.1 0 | Ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажлын талбай дахь бүх машин, тоног төхөөрөмжийн үнэлгээг гүйцэтгэнэ. Үнэлгээний үр дүнд үндэслэн аливаа эрсдлийг бууруулах ажлын төлөвлөгөөг танилцуулна. | Эрүүл мэнд ба аюулгүй байдлын үр ашигтай менежмент | ЕСХБ PR 2 EX Зөвлөмж 98/37/ЕС – Тоног төхөөрөмж. | Дотоод нөөц эсвэл Гадны зөвлөхийн туслалцаа | Ашиглалтанд орсноос хойш нэг сарын дотор | Аваар осол бүртгэл | |
| 2.1 1 | Өөр (орлох) түлш хэрэглэх боломжийг хайх үүднээс байгаль орчны үнэлгээг хийх | Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл буурна | ЕСХБ PR3 ЕСХБ PR6 EX IPPC / Агаарын чанарт нөлөөлөх үйлдвэрлэлийн хог хаягдлын удирдамж. | Дотоод нөөц / Гадны зөвлөхийн туслалцаа. | Эхний үнэлгээ нь ашиглалтанд оруулахаас өмнө хийгдэнэ. Цаашдаа жилийн эцэс болгонд | Өөр түлш хэрэглэх | ЕСХБ-д жил тутамд тайлагнах. |
| 2.1 | Өөр түлш хэрэглэх тохиолдолд түлшний техникийн | Байгаль орчинд | EX IPPC/ | Дотоод нөөц / | Эхний үнэлгээ | Нүүрстөрөгчийн | Ашиглахаас өмнө |

Сэнж Сант Цементийн үйлдвэр: Байгаль орчин ба нийгмийн хөтөлбөрийн төлөвлөгөө

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|----------|--|---|---|--|--|--|---|
| 2 | <p>шаардлага ба түлшний эх үүсвэрийг тэмдэглэнэ. Түлшин дэх галоген ба металын агуулгын хязгаарлалтыг тогтооно.</p> <p>Хамгийн Сайн Боломжит техникийн баримт бичигтэй нийцүүлэхийн тулд өөр түлш хэрэглэх тохиолдолд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг хийх ба үүнд хог хаягдлын менежмент, тоног төхөөрөмжийн тохиромжтой тээвэрлэлтийн үнэлгээ, нөлөөллийг бууруулах арга хэмжээ зэрэг багтана. Өөр түлшийг хэрэглэхээс өмнө олон нийттэй зөвлөлдөнө.</p> | нөлөөлөх нөлөөлөл буурна | Үйлдвэрлэлийн хаягдлыг бууруулах зөвлөмж. | Гадны зөвлөхийн туслалцаа. | нь ашиглалтанд оруулахаас өмнө хийгдэнэ. Цаашдаа жилийн эцэс болгонд | хэмжээг бууруулах | техникийн шаардлагыг тодорхойлох |
| 2.1 3 | Бага NO _x шаталттай зуухыг суурилуулах ба ингэснээр ялгарах хаягдал хийг бууруулуулах боломжтой | Агаарын бохирдлыг бууруулах | ЕХ IPPC/ Агаарын чанарт нөлөөлөх үйлдвэрлэлийн хог хаягдлын удирдамж | Дотоод нөөц. | Тендэрээс өмнө зураг төслийн шаардлагуудыг тогтоох | Шаардлагатай тоног төхөөрөмжинд бага NO _x шаталт байна. | |
| 2.1 4 | <p>Төслийн 2-р шатанд Аммиак/Карбамид хадгалахтай холбоотой аюулгүй байдлын шаардлагын нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэх.</p> <p>Үнэлгээний тайланг олон улсын шийлдэг туршлагын дагуу гаргах.</p> | Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл буурна | ЕСХБ PR3 Шилдэг туршлага | Дотоод нөөц / Гадны зөвлөхийн туслалцаа. | Тендэрээс өмнө зураг төслийн шаардлагуудыг тогтоох | Баримт бичигтэй танилцах | |
| 2.1 5 | <p>Хэрэв түүхий эд эсвэл цаашдын түлшний хэрэглээ нь хүхрийн ислийн 200 мг/Nm³ тооцоот хэмжээнд хүрэхгүй байгаа бол хаягдал хийг хүхэргүй болгох ба үүнийг хэрэгжүүлэх санал болгож буй аргачлалыг боловсруулах шаардлагатай.</p> <p>Техникийн шаардлагын тайланг 2-р шатны эцсийн зураг төслийн ажил дуусахаас өмнө боловсруулна.</p> | Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл буурна | ЕСХБ PR3 ЕХ IPPC/ Агаарын чанарт нөлөөлөх үйлдвэрлэлийн хог хаягдлын удирдамж | Дотоод нөөц / Гадны зөвлөхийн туслалцаа. | Зураг төслийн ажил дуусгавар болохоос өмнө | Хүхрийн ислийн хэмжээг 200 мг/Nm ³ -с ихгүй байлгах | 2р шатны зураг төслийн ажил дуусахаас өмнө ЕСХБ-д тайлагнах |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|----------|---|---|---|--|--------------------------|---|--|
| 2.1 6 | <p>Гаралтын гол цэгүүд: урьдчилан халаагуурын хаягдал гадагшлах хэсэг (хаягдалын зуухын), чулуунцар хөргөгч хэсэг болон цементийн тээрмийн гадагшлах хэсгүүдэд хаягдлыг тогтмол хянах системийг суулгах.</p> <p>Бусад гол хаягдлуудыг (металлын бүлэг, хүчиллэг хийнүүд болон диоксинууд / фуранууд/) Хамгийн сайн боломжит техникт тодорхойлогдсоны дагуу жил бүр шалгах шаардлагатай. Ашиглалтанд бүрэн оруулах явцад хаягдлын түвшин тохиромжтой байгаа эсэхийг бүрэн харуулахын тулд хяналтыг давтамжтайгаар өсгөх хэрэгтэй.</p> <p>СЕМ системийн хүрээнд гарч буй аливаа асуудлыг удирдан шийдэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч, хэрэгжүүлэх / заасан дээд хязгаараас хаягдлын хэмжээ хэтрэх гэх мэт/.</p> | Байгаль орчны хяналт шинжилгээ | ЕСХБ PR3 EX IPPC/ Агаарын чанарт нөлөөлөх үйлдвэрлэлийн хог хаягдлын удирдамж | Дотоод нөөц. | Ашиглалтанд орохоос өмнө | Хэрэгжүүлсэн ажлуудын баримт, хийгдсэн засваруудын бүртгэл. | Цаашдаа хийх хяналт шалгалтанд ашиглах үүднээс бүртгэлийн баримтууд талбай дээр хадгалагдана |
| 2.1 7 | СЕМ-ийг удирдахад ашиглах техник үйлчилгээ болон туршилт шалгалтын хуваарийг боловсруулах | Тоног төхөөрөмжийн үр дүнтэй байдал ба нарийн тохирол | Суурилуулсан тоног төхөөрөмжүүдтэй холбоотой ISO стандартууд | Дотоод нөөц / Гадны зөвлөхийн туслалцаа. | Ашиглалтанд орохоос өмнө | Хэрэгжүүлсэн ажлуудын баримт, туршилтын бүртгэл. Туршилтын хуваарийг санал болгосон үйлдвэрлэлийн дамтамжийн дагуу гаргана. | Цаашдаа хийх хяналт шалгалтанд ашиглах үүднээс бүртгэлийн баримтууд талбай дээр хадгалагдана |
| 2.1 8 | Цэвэршүүлэх систем, холбогдох шугам хоолойны ажлуудыг боловсруулах, хэрэгжүүлэх | Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл буурна | Хог хаягдал, бохирын хэм хэмжээг заасан | Дотоод нөөц / Гадны зөвлөхийн | Ашиглалтанд орохоос өмнө | Хэрэгжүүлсэн ажлуудын баримт, | Цаашдаа хийх хяналт шалгалтанд |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|----------|--|---|--|---|--------------------------|--|--|
| | | | Монгол улсын нормын дагуу | туслалцаа. | | хийгдсэн засваруудын бүртгэл. Монгол улсын хуульд тусгагдсан зөвшөөрлийн нөхцлүүдийг хангах. | ашиглах үүднээс бүртгэлийн баримтууд талбай дээр хадгалагдана |
| 2.1 9 | <p>Тоног төхөөрөмжүүдийг дараах шаардлагуудад нийцүүлэн угсарч, ашиглах:</p> <ul style="list-style-type: none"> - Төслийн 1-р шатанд азотын исэл 800 мг/Nm³, 2-р шатанд 500 мг/Nm³ (SNCR нь 2 дахь шатанд шаардлагатай) - Тоосжилтын хэмжээ 20 мг/Nm³-с бага байх. - 200 мг/Nm³ хүхрийн исэл. - Бусад хаягдлууд (жишээ нь метал, HF/HCl гэх мэт) БОННУ-ний Хамгийн сайн боломжит техникийн баримтанд дурдагсаны дагуу <p>Тоос цуглуулах систем (жишээ нь уутан шүүлтүүр)-ийн менежмент ба засвар үйлчилгээний журмыг боловсруулах. Үүнд хуримтлуулсан тоосыг процесст эргүүлэх зэрэг багтана.</p> <p>Шүүлтүүр шалгах болон засварлах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх.</p> <p>Хэвийн бус болон гэнэтийн нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах</p> | <p>Агаарын бохирдлын бууралт</p> <p>Тоног төхөөрөмжийн үр дүнтэй ашиглалт</p> | Европын Холбооны (ЕХ) IPPC / Агаарын чанарт нөлөөлөх үйлдвэрлэлийн хог хаягдлын удирдамж | Дотоод нөөц SNCR хэрэгжүүлэлтийн зардал | Ашиглалтанд орохоос өмнө | Хэрэгжүүлсэн ажлуудын баримт, хийгдсэн засваруудын бүртгэл. | Цаашдаа хийх хяналт шалгалтанд ашиглах үүднээс бүртгэлийн баримтууд талбай дээр хадгалагдана |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|----------|---|--|---|---------------------------------------|--|------------------------------------|---|
| 2.2 0 | Ашиглалтын ажил эхэлснээс хойш таван жилийн дотор Дэлхийн бизнесийн зөвлөлийн "Цемент тогтвортой үндэс"-д нэгдэх. | Олон улсын шилдэг практикт нийцсэн гүйцэтгэл, ашиглалт | WBCSD Цементийн салбарын шалгуур үзүүлэлтүүд (Цемент тогтвортой үндэс). | Дотоод нөөц. | Үйлдвэр ашиглалтанд орсноос хойш 5 жилийн дотор | Баталгаажсан WBCSD | |
| 2.2 1 | ISO5001 стандартын дагуу эрчим хүчний менежментийн системийг хэрэгжүүлэх. Энэ нь өөртөө GHG менежментийн стратегийг багтаана (түлшний бүх эх үүсвэр болон нүүрсэн галлагаатай цахилгааны эх үүсвэрийг агуулна). | Нөөцийн үр ашигтай менежмент | ECXB PR 3 ба PR6. | Дотоод нөөц. | Үйлдвэр ашиглалтанд орсноос хойш 5 жилийн дотор | ISO5001 стандартын гэрчилгээ | |
| 2.2 2 | 5 жил тутамд усны бүрэн аудит явуулах, үүнд гүний усны усны түвшинг болон өнөөгийн хэрэглээнээс үүсч буй нөлөөллийг хэмжих ажлууд багтана. | Усны хэрэглээг хянаж, багасгах аргуудыг үнэлэхийн тулд усны аудит хийх. Түүнчлэн одоогийн ус ашиглалт нь биологийн тархалт ба хүмүүст нөлөөлж байгаа эсэхийг тодорхойлох, шаардлагатай бол бууруулах | ECXB PR 3, 6 ба Шилдэг туршлага | Гадаад | Ашиглалтанд орсноос хойш 2 жилийн дараагаас эхлэн 5 жил тутамд | | Аудитийн цар хүрээ нь зээлдэгчид болон хувьцаа эзэмшигчдээр зөвшөөрөгдсөн байх ёстой. |

| No. | Байгаль орчинтой холбоотой ажлуудын төлөвлөгөө | Байгаль орчны эрсдэл / Ач холбогдол | Холбогдох стандарт (хууль дүрэм / шилдэг туршлага) | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ / Нөөцүүд | Төлөвлөсөн огноо | Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI) | Тайлбар |
|-----|--|-------------------------------------|--|---------------------------------------|------------------|------------------------------------|---------|
| | | арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | |